

БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ

Эдийн засгийн өсөлт 2025 онд 8.0 хувь орчимд хадгалагдах төлөвтэй байна.

Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал зэрэг уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарын өсөлтийг дэмжихээр байна. Энэ онд эдийн засгийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх тоног төхөөрөмж, машин механизмын импортын өсөлт өндөр байсан нь цаашид эдийн засгийн потенциалыг нэмэгдүүлж, өсөлтийг дэмжихээр байна. Тухайлбал, уул уурхайн салбарт ашиглагддаг хүнд машин механизмуудын импорт өмнөх оноос 2 дахин, ачааны тээврийн хэрэгсэл 85 хувиар тус тус өссөн зэрэг нөлөөгөөр 2025 онд уул уурхай болон тээврийн салбарын өсөлт өндөр байхаар байна.

Мөн эрчим хүчний салбарт хэрэгжиж буй Бөөрөлжүүт, Чойбалсангийн станц, Багануурын батарей хуримтлуурын бүтээн байгуулалтууд нийт эдийн засгийн потенциал хүчин чадлыг дэмжинэ. Түүнчлэн, сүүлийн 7 улирал дараалан агшаад буй хөдөө аж ахуйн салбар ирэх оноос сэргэж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж эхэлнэ гэж тооцож байна. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг гаалийн татвараас хөнгөлсний үр дүнд хүнсний үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн импорт энэ онд өссөний зэрэгцээ хөдөө аж ахуйн салбар сэргэхээр байгаа нь цаашид

боловсруулах салбарын өсөлтийг дэмжихээр байна. Мөн эдийн засгийн дотоод эрэлтийн идэвхжил хадгалагдаж, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийг дэмжихээр байна.

Нүүрс болон зэсийн баяжмалын экспорт 2024 онд төлөвлөсөн хэмжээг давахаар байгаа бөгөөд Монгол Улс 2025 онд 83 сая тонн нүүрс, 1,780 мянган тонн зэсийн баяжмал экспортлохоор зорьж байна. Гэсэн хэдий ч дэлхийн эдийн засаг, геополитикийн тодорхой бус байдлаас шалтгаалсан экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн тогтворгүй байдал манай улсын экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Инфляц 2025 онд төв банкны зорилтот түвшний дээд хязгаарт хүрэх төлөвтэй байна.

Инфляц 2025 онд төв банкны зорилтот түвшний дээд хязгаар орчимд, дунджаар 7.2 хувь байх хүлээлттэй байна. Хөдөө аж ахуйн салбарын агшилтаас үүдэлтэйгээр махны нийлүүлэлт буурч, махны үнэ улирлын хандлагаасаа өндрөөр өсөх, эрчим хүчний тарифын нэмэгдлийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний инфляц өсөх төлөвтэй байна. Мөн геополитикийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистикийн саатлаас үүдэн импортын инфляц нэмэгдэх эрсдэлүүд хэвээр байна.